

Сургалтын хөтөлбөр, үнэлгээний бодлогын удирдлага, зохицуулалт, тайлагналт хариуцсан ахлах шинжээч, Даваадорж Даваасүрэн

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, үнэлгээ, хэрэгжилтийг боловсронгуй болгох							
1	Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, тохирц, нийцлийг шалгах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана.	Холбогдох тушаал шийдвэр, төлөвлөгөө гарсан байна. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, түшиц сургуулиудад туршсан байна.	МУЗГ 176 дугаар тогтоолоор батлагдсан үзэл баримтлал	Тушаал шийдвэрийг албажуулан, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн байна.	ЗГ-ын 2024 оны 176-р тогтоолоор батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн бага боловсрол сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэн боловсруулж, тохирц нийцлийг шалган турших ажлын хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Сургуулийн өмнөх, бага боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэн боловсруулах, сурах бичгийн эх зохиох багийн бүрэлдэхүүн батлах тухай" А/06, Боловсролын сайдын "Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн туршилтын сургалтын төлөвлөгөө батлах тухай" А/57 дугаар тушаал, Боловсролын сайдын 2024 оны "Сургалтын төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэхтэй холбогдох зарим арга хэмжээ авах тухай" А/64 дүгээр тушаалыг тус тус батлуулан хэрэгжүүлж байна.Эдгээр тушаалын БСҮХ-ийн удирдлага доор багууд бага боловсролын сургалтын хөтөлбөрийн эхний төслийг боловсруулан экспертийн санал зөвлөмжийг тусган	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					сайжруулж, 1-5 дугаар ангийн Монгол хэл, Унших бичиг, Математик, Түмэн бодис, Компьютерийн ухаан, Хөгжим, Зураг урлалын сурах бичгийн 1 дүгээр улиралд хэрэглэх туршилтын эхийг бэлтгэн хэвлүүлсэн. Бага боловсролын түвшинд Монгол хэл, +Унших бичиг, Математик, Би Монгол хүн, Түмэн бодис, Компьютерийн ухаан, Хөгжим, Зураг урлал, Биеийн тамир эрүүл мэнд, Казах болон Тува хэлний хөтөлбөр, сурах бичиг, дасгал ажлын дэвтрийн тохирц нийцлийг хот, хөдөөгийн нийт 26 сургуульд шалган турших туршилтыг 2024 оны 11 дүгээр сараас эхлүүлээд байна. Тодруулбал судлагдахуун тус бүрийг нийслэлийн 1, аймгийн төвийн 1, сумын 1 сургуульд, Казах, тува хэлний сургалтын хөтөлбөрийг Баян-Өлгий аймгийн аймгийн төвийн 1, сумын 1 сургуульд тус тус туршиж байна. Хөтөлбөрийн шинэчлэлийн шинэлэг талуудаас дурдвал: -Бага боловсролын 1-р ангийн бэлтгэл 60 цагийн агуулгыг СӨБ-ын бэлтгэл бүлэгт үзэж судлахаар оруулсан. Компьютерийн ухаан хичээлийг бага боловсролын түвшнээс оруулах ба сурах бичгээс гадна дасгал ажлын дэвтэр, багшийн ном зэргийг цогцоор боловсруулж байна. Туршилтын үйл ажиллагаатай танилцан хөтөлбөрийн багуудад зөвлөмж санал өгч ажиллаж байна. Хавсралт: 3 файл		
2	Ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангид "Ажил мэргэжлийн чиг баримжаа	Тушаал шийдвэр, хэрэгжилт	-	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хичээл сонголтод дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид ажил мэргэжлийн чиг баримжаатай болох, түүнд нийцүүлэн ахлах ангийн хичээл сонголт хийхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, хичээл сонголтод бэлтгэх үйл ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ:

	олгох, ахлах ангийн хичээл сонголтод дэмжлэг үзүүлэх” үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангана.			тушаал,шийдвэрийг албажуулж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажилласан байна.	боловсролын сургуулийн 9 дүгээр ангид 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн зохион байгуулах тухай Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн "Ажил, мэргэжлийн чиг баримжаа-Хичээл сонголтын бэлтгэл" үйл ажиллагаа зохион байгуулах тухай" А/123 дугаар тушаалын төслийг боловсруулан албажуулж, Боловсролын ерөнхий газар, аймаг, нийслэлийн боловсролын газруудад хүргүүлсэн. Тус тушаалын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор БЕГ-ын Суралцагчийн хөгжлийн газрын ажил мэргэжлийн чиг баримжаа хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ажилласан. Тушаалын хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангийн нийт 1981 бүлгийн 55,538 суралцагчид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагааг 2024-2025 оны хичээлийн жилд, 299,923,400 төгрөгийн санхүүжилтээр, хичээлийн жилийн 2,3 дугаар улиралд зохион байгуулна. Хавсралт: 1 файл		100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3	Ерөнхий боловсролын сургуулиудад олон улсын PEARSON, EDUTEN цахим системт суурилсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохицуулалтаар хангана.	Сайдын тушаал, шийдвэр, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн анги, сургуулийн тоо	ЕБС-ийн 5,6 дугаар ангид хэрэгжсэн.	2024-2025 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хамрах хүрээг /5-7 дугаар анги, туршилт 3,4 р анги/ тогтоосон шийдвэр, тушаал албажсан байна.	1. БШУ-ны сайдын 2023 оны А/353 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу 2024-2025 оны хичээлийн жилд цахим системд суурилсан англи хэлний Pearson English хөтөлбөрийг төрийн өмчийн ерөнхий боловсролын 705 сургуулийн 5,6,7 р ангийн нийт 224,718 суралцагч судалж байна. Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн "Цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөр турших, хэрэгжүүлэх, жагсаалт батлах тухай" А/68 дугаар тушаалыг боловсруулан батлуулсны дагуу тус хөтөлбөрийг 2024-2025 оны хичээлийн жилд зарим төрийн өмчийн ерөнхий	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн

					боловсролын 105 сургуулийн 3, 4 дүгээр ангид туршилтаар, "Мэдлэ" цахим системээр англи хэл сонгон судлах 10, 11, 12 дугаар ангийн суралцагчид тус тус судалж байна. 2. БШУ-ны сайдын А/312 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу 2024-2025 оны хичээлийн жилд математикийн сургалтын Эдүтэн цахим системийг төрийн өмчийн ерөнхий боловсролын 705 сургуулийн 1-5 дугаар ангийн 379,647 суралцагч хэрэглэн математикийн хичээлийн хөтөлбөрөөр эзэмших чадвараа ахиулах болон сурлагын хоцрогдол арилгахад чиглэсэн дасгал даалгаврыг долоо хоногт 1 цагаар гүйцэтгэн суралцаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр Эдүтэн байгууллагын зөвлөх баг болон БЯ, БЕГ, БСҮХ-ийн хамтарсан Эдүтэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний баг хэрэгжилтэд тулгарч байгаа асуудал, бэрхшээлүүдийг шийдвэрлэн багш нар арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Эдүтэн цахим системийг төрийн өмчийн ерөнхий боловсролын 705 сургуулийн 1-5 дугаар ангийн 379,647 суралцагч 7 хоногт 1 цагаар математикийн хичээлийн хөтөлбөрөөр эзэмших чадвараа ахиулах болон сурлагын хоцрогдол арилгахад чиглэсэн дасгал даалгаврыг гүйцэтгэж байна. Боловсролын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/182 дугаар тушаалаар Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн Монгол хэлний хичээл, сургалтын чанар, хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор цахим системийг хөгжүүлэх ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Хавсралт: 2 файл	хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	---	---

4	Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг зохион байгуулах, зөвлөмж боловсруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана.	Тушаал, зөвлөмж	-	Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг зохион байгуулах тушаал шийдвэрийг албажуулж, зөвлөмж боловсруулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байна.	ЕБС-ийн нэгдүгээр ангийн суралцагчдын Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг зохионбайгуулах тухай Боловсролын сайдын 2024 оны 08 сарын 27-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар шийдвэрийг албажуулан батлуулсан. Тус тушаалаар Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн суралцагчдын "Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ"-г 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 25-ны өдрүүдэд зохион байгуулахаар шийдвэрлэж, төсөв зардлыг баталсан бөгөөд үнэлгээг Боловсролын үнэлгээний төв нэгдсэн удирдлагаар ханган Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, аймаг, нийслэлийн боловсролын газруудтай хамтран заасан хугацаанд зохион байгуулж, тайланг боловсруулсан нь одоогоор хяналтын уншилт хийгдэж байна.Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний тайлан, мэдээлэлд үндэслэн Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн сургуулийн өмнөх болон бага боловсролын багш нарт зориулсан зөвлөмж боловсруулна. Хавсралт: 1 файл	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
5	Улсын төрөлжсөн олимпиад, олон улсын олимпиадыг зохион байгуулах, олон улсын олимпиадад амжилттай оролцсон суралцагч, багш,	Хамрагдсан багш, суралцагчийн тоо	-	Олон улсын олимпиадад 6 төрлөөр багууд оролцсон байна. Амжилттай оролцогчдыг шагнаж, урамшуулсан байна.	1. Боловсролын ерөнхий хуулийн 27.15-д заасны дагуу Улсын олимпиад зохион байгуулах журмын төслийг боловсруулах, сайжруулахад Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн газрын мэргэжилтнүүд, Улсын олимпиад зохион байгуулах дэд хороодтой хамтран ажилласнаар тус журам нь Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/420 дугаар тушаалаар батлагдсан. 2. Дээрх журмын дагуу 2023-2024 оны хичээлийн жилд БЕГ-ын даргын А/56, А/100 дугаар тушаалаар улсын олимпиадыг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ

	олимпиадын хороодыг шагнаж, урамшуулах үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангана.				зохион байгуулах төсвийг /536,782,600 төг/ батлан 12 судлагдахууны олимпиадыг Улсын олимпиадын хороод 3-5 дугаар сард зохион байгуулж, 9 ба 12-р ангийн 2000 суралцагч, 200 гаруй багш оролцсон. Нийт оролцогчдын 11% нь буюу 218 суралцагч медаль хүртсэн нь өмнөх жилүүдээс оролцогч болон шагналт байрын тоо нэмэгдсэн, Монгол хэл-Уранзохиол, Монгол бичиг хичээлийн олимпиадыг тус тусад нь зохион байгуулсан онцлогтой байна. Монгол улсаас 2024 онд олон улсын 7 төрлийн олимпиадад 31 сурагч оролцсоноос 23 нь медальт байранд шалгарсан бөгөөд олон улсын олимпиадад өндөр амжилт гаргасан суралцагчид болон тэднийг бэлтгэсэн Олимпиадыг зохион байгуулах хороодод Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналыг 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр гардуулсан. Олон улсын олимпиадаас медаль хүртсэн суралцагчид дэлхийн тэргүүлэх 100-д багтдаг их, дээд сургуульд элсэх эрх авснаар “Ерөнхийлөгчийн илгээлт 2100” тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжтой болдог. Хавсралт: 3 файл		төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
6	ЕБС-д хэрэгжүүлж буй Аюулгүй амьдрах ухааны хөтөлбөрийн хэрэгжилт, ОУХС-тай сургуулиудын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ	Хяналт шинжилгээний тайлан	-	ОУХС-тай сургууль, ААУ-ны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, тайлан, дүгнэлт гарсан байна.	Боловсролын сайдын баталсан 2024 оны А/75 тушаалаар ЕБС-д хэрэгжүүлж буй “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хамтран ажиллаж, багшийн болон суралцагийн асуулгыг нэгтгэн дүн шинжилгээ хийж, тус хяналт шинжилгээний ажлын тайланд тусгуулж ажилласан. “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг ЕБС-д хэрэгжсэн байдлын судалгааг 2024 оны 10 дугаар сард зохион байгуулж, ЕБС-ийн 30 сургууль, 87	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ

	хийхэд Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газартай хамтран ажиллана.				сургалтын менежер, нийгмийн ажилтан, 902 багш, бага, дунд, ахлах ангийн 1828 суралцагч хамрагдсан бөгөөд зарим үр дүнгээс дурдвал судалгаанд хамрагдсан нийт сургуулийн 28.0 хувь нь л сургуулийн гадна, дотно орчны эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулдаг, бөгөөд тус хөтөлбөрийг үр дүнтй хэрэгжүүлэхэд сургуулийн орчин, сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулж, дэмжлэг үзүүлэх шаардлага байгаа нь харагдсан. Жишээлбэл, сургуульд төлөвлөгдсөн аврах гарц, тэмдэглэгээ байдаг ч ашиглалтын бэлэн байдлыг хангаагүй, дийлэнх нь цоожтой байгаа нь гамшиг ослын үед аюулгүй нүүн шилжих боломжгүй, эрсдэлийг нэмэгдүүлж байна. Орчны хэрэглэгдэхүүний нөөцийн бүрдүүлэлтийг үнэлэхэд гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, аврах зам гарцын зураг, тэмдэг, тэмдэглэгээний бүрдүүлэлт 65.6 хувь, анги бүрт байвал зохих эмнэлгийн анхан шатны тусламжийн хэрэгсэл (ЭАШТ), гамшиг, ослын үеийн бэлэн байдлыг хангах цүнхний бэлтгэл 34.3 хувийн биелэлттэй байна. Сургуулийн гадаад орчинд үер уснаас хамгаалсан суваг шуудуу, стандартын шаардлага хангасан аянга зайлуулагч, гал түймрийн аюулын үед галын машин чөлөөтэй орох зам байхгүй, талбай хангалтгүй гэсэн эрсдлүүд зонхилох хувийг эзэлж байна.Тус хяналт шинжилгээний тайлан, дүгнэлтийг ХШҮДАГ-аас онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын шадар сайдад хүргүүлсэн. Тайлан, зөвлөмжийг Боловсролын ерөнхий газар болон ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлсэн байна. Хавсралт: 1 файл	төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--	--

7	PISA - 2025 олон улсын сурлагын амжилтын судалгааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, туршилтын судалгааны ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана.	Туршилтын судалгаа	Pisa 2022 судалгааны үр дүн	-	Боловсролын ерөнхий хуулийн 35.6 дугаар зүйлд “Боловсролын чанарыг гурван жил тутам олон улсын эрх бүхий байгууллагаар үнэлүүлнэ” гэж заасны дагуу OECD буюу Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас зохион байгуулдаг PISA 2025 сурлагын амжилтыг үнэлэх олон улсын судалгаанд үргэлжлүүлэн оролцохоор бэлтгэл хангах зорилгоор олон улсын судалгааны даалгавар, аргачлалыг таниулах, түгээн дэлгэрүүлэх болон PISA 2022 судалгааны үр дүнг танилцуулах цахим сургалтыг БҮТ-өөс 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрийн хооронд бүсчилсэн байдлаар зохион байгуулсан. Сургалтад аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтсийн үнэлгээ хариуцсан болон судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүд, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн үнэлгээ хариуцсан менежер, ахлах ангид байгалийн ухаан (хими, физик, биологи, газар зүй), математик, мэдээлэл зүй, монгол хэл уран зохиол, гадаад хэлний хичээл заадаг багш нар хамрагдсан. Мөн PISA сурлагын амжилтын нээлттэй даалгавар, аргачлалыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээний хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 01, 2-ны өдрүүдэд түүвэрт сонгогдсон төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын 15 настай 1500 орчим суралцагчийг судалгаанд хамруулан, байгалийн ухаан, математик, унших чадварыг үнэлэх компьютерт суурилсан шалгалт, судалгааг зохион байгуулсан.	4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
8	Ерөнхий боловсролын	Багшийн гүйцэтгэлийн	Сургууль /байгууллаг	Сургууль /байгууллага/ -	Ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ 2024 оны	4-р сар, 5-р сар,	Өөрийн үнэлгээ:

	сургалтын байгууллагын болон багшийн ажлыг үнэлэх, дүгнэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангана.	үнэлгээ, байгууллагы үнэлгээ зохион байгуулагдсан байх	а/ - 74.22 Сургууль /багш/ - 75.71	76,5 Сургууль /багш/ - 77,5	04 дүгээр сарын 29-нөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Тус үнэлгээнд улсын хэмжээнд 708 сургууль хамрагдсанаас улсын дундаж 78.62%, I индексийн түвшинд 62 сургууль (нийт сургуулийн 8.76%), II индексийн түвшинд 106 (нийт сургуулийн 14.97%), III индексийн түвшинд 118 (нийт сургуулийн 16.67%), IV индексийн түвшинд 105 (нийт сургуулийн 14.83%), V индексийн түвшинд 315 (нийт сургуулийн 44.49%) сургууль тус тус үнэлэгдсэн байна. ЕБС-ийн багшийн үнэлгээнд 28743 багш хамрагдсан ба улсын дундаж 77%. Үүнээс: I индексийн түвшинд 1874 (нийт багш нарын 6.5%), II индексийн түвшинд 5481 (нийт багш нарын 19.0%), III индексийн түвшинд 4604 (нийт багш нарын 16.0%), IV индексийн түвшинд 4419 (нийт багш нарын 15.3%), V индексийн түвшинд 12365 (нийт багш нарын 43.0%) багш тус тус үнэлэгдсэн байна.	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
9	Ерөнхий боловсролын сургуульд авилгыг үл тэвчих, шударга ёсны агуулга бүхий "Ёс суртахууны хариуцлага" хөтөлбөр хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.	Авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг багтаасан сургалтын хөтөлбөр, хэрэгжүүлэх тушаал	-	Авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг багтаасан сургалтын хөтөлбөрийг ЕБС-д хэрэгжүүлэх тушаал шийдвэр гарч, хэрэгжиж эхэлсэн байна.	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 9.3.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд авилгыг үл тэвчих, шударга ёсны агуулга бүхий "Ес суртахууны хариуцлага" сургалтын дэмжих хөтөлбөрийг БСҮХ, АТГ хамтран боловсруулахад дэмжлэг үзүүлж, туршилтын хичээл зохион байгуулах, хөтөлбөрийг агуулгыг бүтэцчилэх зөвлөмжийг өгч ажилласан. Үүний үр дүнд тус хөтөлбөрийг өмчийн бүх хэлбэрийн ЕБС-ийн 10 дугаар ангид багш зохицуулах цагийн хүрээнд хэрэгжүүлэх тухай шийдвэрийг Боловсролын сайдын 2024 оны 10 сарын 10-ны өдрийн А/137 дугаар тушаалаар батлуулан, Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 2/1578 дугаатай албан бичиг, дээрх тушаал, хөтөлбөрийг АТГ, Боловсролын	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал:

					ерөнхий газар, аймаг, нийслэлийн боловсролын газруудад хүргүүлсэн. БСҮХ болон АТГ хамтран тус хөтөлбөр, хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжийг хэвлүүлэн түгээх, багш, нийгмийн ажилтнуудад сургалт зохион байгуулах ажлыг зохион байгуулж байна. Хавсралт: 2 файл		100%
1.2. Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын менежментийг боловсронгуй болгох, ерөнхий боловсролын салбарын богино, дунд хугацааны арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх							
10	Иргэний эрүүл мэндийн боловсролын дээшлүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангана.	Арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилт	ЗГ-ын 2023 оны 321 дүгээр тогтоол	Төлөвлөгөөнд 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан ЕБ-ын салбарит хамаарах үйл ажиллагааны хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж, тайлагнасан байна.	Засгийн газрын 2023 оны "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай" 321 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн сайд, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг боловсруулан БШУ-ны сайдын албан бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн. Тус арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт БШУЯ-аас ЕББУЗГ-ын ахлах шинжээч Д.Даваасүрэн, БНБТГ-ын шинжээч Ц.Чимэдлхам нар ажиллаж, яамдаас ирсэн саналыг хэлэлцэн төлөвлөгөөний төслийг сайжруулж, арга хэмжээ, төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайд, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/75/09/73/34 дүгээр хамтарсан тушаалаар батлуулсан. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланд тус арга хэмжээний талаар болон 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг тайлагнаж	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					ажиллалаа. Хавсралт: 1 файл		
1 1	Сургуулийн менежментийг сайжруулах зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Тушаал шийдвэр, хэрэгжилтийн дэмжлэг	БШУС-ын А/49 тушаал	Тушаал шийдвэрийг албажуулан хэрэгжүүлж эхэлсэн байна.	1. Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах хөтөлбөр арга хэмжээг 2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 120 сургуульд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай Боловсролын сайдын 2024 оны 09 сарын 09-ний өдрийн А/68 дугаар тушаалаар шийдвэрлэсэн. 2. Боловсролын сайдын 2024 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн" А/72 дугаар тушаал, Боловсролын ерөнхий газрын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн "Хүсэлт хүргүүлэх тухай" 01/4414 дүгээр албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн "Сургуулийн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх" үйл ажиллагаанд хамрагдах ерөнхий боловсролын 120 сургуулийн жагсаалтыг Боловсролын сайдын 2024 оны 10 сарын 10-ны өдрийн А/137 дугаар тушаалаар батлуулав. Тус арга хэмжээг боловсролын ерөнхий газар нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, төрийн бус байгууллагын оролцоотойгоор зохион байгуулж байна. Хавсралт: 2 файл	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1 2	Гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр ерөнхий боловсролын салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг	Төслийн удирдах хорооны баталсан төлөвлөгөө (GPE, АХБ-ны ЭЗХБЧХД төсөл)	-	Төсөл хөтөлбөрүүдийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна.	БШУЯ, АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэх төслийн 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсвийг Сангийн ямаар батлуулахад төслийн багтай хамтран ажиллав. Тус төслийн хүрээнд 2024 онд - Гурван ээлжээр хичээллэх эрсдэлтэй сургуулиудад дижитал танхим нийлүүлж, үр дүнтэй ашиглахад арга зүйн дэмжлэг үзүүлэх, - ЕБС-ийн гүйцэтгэл, үр дүнд суурилсан тогтолцоог бэхжүүлэх замаар сургуулийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн

	удирдлага, зохицуулалтаар хангана.				менежментийг сайжруулах -ЕБС-ийн удирдах ажилтнууд болон Нийслэл, аймгуудын боловсролын газруудын мэргэжилтнүүд,НТСТ-ийн мэргэжилтнүүдэд зориулсан мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг онлайн систем ашиглан боловсруулж, сургалт зохион байгуулах, Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулан сургалтын хөтөлбөрийн төсөл боловсруулах (суралцагчийн үнэлгээний туршилтыг зохион байгуулах, - Байгалийн ухааны лабораторийн ур чадвар, удирдлагын чиглэлээр байгалийн ухааны багш нарын 30%-ийг сургалтад хамруулах ажлуудад нийт 1.6 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн. 2. GPE-2022 дугаар бүхий “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн хосолсон сургалт бүрэлдэхүүний зорилтот ЕБС-ийн багш нарт зориулсан сургалтыг зохион байгуулах шийдвэр, холбогдох зардлын төсвүүд, Хосолсон сургалтын туршилтын удирдамж зэргийг боловсруулж, БШУ-ны сайдын тушаалуудаар батлуулан боловсролын газар, зорилтот сургуулиудыг мэдээллээр хангаж ажиллав. мөн дээрх төслүүдийн санхүүжилтээр зохион байгуулах сургалт, үйл ажиллагааны холбогдох гэрээг боловсруулан, ХЭЗХ-ээс хянуулан албажуулснаар ерөнхий боловсролын салбарт хэрэгжиж төлөвлөгөөт арга хэмжээнүүд хугацаандаа хэрэгжлээ.	р сар, 12-р сар	даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1.3. Ерөнхий боловсролын салбарын нийтлэг харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлага, зохицуулалтаар хангах							
1 3	Ерөнхий боловсролын сургуульд зайн болон цахим сургалт зохион	Журмын төсөл, баталсан шийдвэр	-	Журмын төсөл боловсруулсан байна.	Журмын анхны төслийн боловсруулсан. Яамны бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор "Ерөнхий боловсролын сургуульд зайн болон цахим сургалт зохион байгуулах журам"-ыг чиг	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-	Өөрийн үнэлгээ: 70% Нэгжийн

	байгуулах журам боловсруулна.				үүргийн дагуу Цахим боловсролын газар хариуцан боловсруулж, батлуулахаар болсон. Боловсролын Дэлхийн Түншлэл (GPE) олон улсын байгууллагын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих" төсөл, АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах" төслийн Хосолсон сургалт бүрэлдэхүүний хүрээнд зохион байгуулах сургалт, нийт 97 сургуульд хэрэгжүүлэх хосолсон сургалтын туршилтын үр дүнг тус журамд тусгахаар ажиллаж байна. "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих" төсөл нь ЕБ-ын 50 сургуульд, "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах" төслөөс ЕБС-ийн 47 сургуульд тус тус хосолсон сургалтын орчин бүрдүүлэн багш нарт сургалтыг үе шаттай зохион байгуулсан. Мөн "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих" төслийн зөвлөх багаас Хосолсон сургалтын туршилтыг 20 сургуульд зохион байгуулж байгаа бөгөөд Хосолсон сургалтын багшийн ур чадварыг стандартын төслийг боловсруулан хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж байгаа зэрэг ажлын үр дүнг тус журмын төсөлд тусгах хэрэгцээ шаардлага бий болсон. Төслийн эдгээр ажлуудыг зохион байгуулах тушаал, шийдвэр, удирдамжийг албажуулах, хэлэлцүүлгийг зохион байгуулахад хамтран ажиллаж байна. Хавсралт: 2 файл	р сар, 12-р сар	даргын үнэлгээ: 60% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
1 4	Төрөлжсөн сургалтын хөтөлбөрт тавих	Журмын төсөл, баталсан шийдвэр	-	Журмыг батлуулан, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн "Журам батлах тухай" А/262 дугаар тушаалаар "Төрөлжсөн сургалт зохион байгуулах журам"-ыг баталж,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар,	Өөрийн үнэлгээ: 100%

	шаардлага болон нэмэлт зардал, сургалт зохион байгуулах журам боловсруулж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ.			байна.	Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн бүртгэлд 6844 дугаартай бүртгэгдсэн. Журмын төслийг боловсруулан, хэлэлцүүлэх, сайжруулахад БНБТГ-тай хамтран ажилласан бөгөөд батлагдсан журмыг Боловсролын ерөнхий газар, аймгийн БШУГ, Нийслэлийн боловсролын газруудад ЕББУЗГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 5/2449 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Журмыг хэрэгжүүлэхэд аймаг, нийслэлийн Боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулиудад гарч буй асуудал бэрхшээл, ойлголтын зөрүүг арилгахад зөвлөж дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Хавсралт: 1 файл	5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1 5	Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих журам боловсруулна.	Журмын төсөл, баталсан шийдвэр	-	Журмыг батлуулсан байна.	"Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам", "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам"-ын төслийг тус тус боловсруулж, холбогдох талуудаас санал авсан бөгөөд батлах шийдвэр хянагдаж байна. Энэ журмаар (i) багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагаа нь багшийг дадлагажуулах болон мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагаа байх, (ii) багшийг дадлагажуулах үйл ажиллагаа нь багшийг багшлах ажилд дагалдуулан сургах, зөвлөн туслахад чиглэсэн цогц хөтөлбөртэй байх, (iii) багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааг сургалтын байгууллага болон орон нутгийн түвшинд зохион байгуулах, (iv) орон нутаг, үндэсний түвшинд зохион байгуулах багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааны агуулга нь хүүхдийн нас, хөгжлийн онцлогт нийцүүлэн ажил үүргээ	5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 60% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, мэргэшүүлэхэд чиглэсэн шатлан гүнзгийрсэн байх, (v) багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт нь үндсэн болон төрөлжсөн сургалт гэсэн төрөлтэй, үндсэн сургалтын агуулга нь сургалтын хөтөлбөр таниулах, түүнийг хэрэгжүүлэх арга зүй, технологийг түгээхэд чиглэх, (vii) төрөлжсөн сургалт нь багш, ажилтанд ажил үүргээ үр дүнтэй гүйцэтгэх, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах онол, арга зүйн мэдлэг, чадварыг хөгжүүлэхэд чиглэх, (viii) мэргэжлийн хөгжлийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын “Багшийн хөгжлийн зардал”-аас санхүүжүүлэхээр тус тус зохицуулсан. Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт нь багшийн чадамжийн стандартад заасан шаардлагад суурилсан 4 түвшин, удирдах ажилтны чадамжид суурилсан 3 түвшинтэй байхаар журамд тусгасан нь журмын шинэлэг тал болно. Хавсралт: 2 файл		
1 6	Гадаад улсын эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын боловсролын сургалтын байгууллагад шилжин	Журмын төсөл, БЕГ-ын даргын тушаал	-	Журмыг БЕГ-ын даргын тушаалаар батлуулсан байна	Гадаад улсын эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын ерөнхий боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах тохиолдолд суралцагчийн эзэмшсэн чадамжийг үнэлж, дүйцүүлэх журмыг төслийг БЕГ-ын СХҮХГ-тай хамтран боловсруулж, БЕГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлуулсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140770954891 Журамд гадаад улсын эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ

	суралцах тохиолдолд суралцагчийн эзэмшсэн чадамжийг үнэлж, дүйцүүлэх, журам боловсруулахад БЕГ-тай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлнэ.				ерөнхий боловсролын сургалтын байгууллагын төгсөх ангид суралцах хүсэлтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, бусад ангид шилжин суралцах хүсэлтийг ЕБС тус тус шийдвэрлэхээр, -Суралцагчийг хуульд заасан тухайн насанд нь тухайн түвшний боловсролыг эзэмшүүлэхийг зорих -Шаардлагатай агуулгын зөрүү арилгах, нөхөн эзэмшүүлэх үйл ажиллагааг ЕБС зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх -БШУГ, БЕГ дээр төвлөрөл ачаалал үүсгэхгүй байх -Гадаадад амьдарч байгаад ирсэн суралцагчид МУ-ын боловсролын үйлчилгээг үзүүлэхдээ гарч болох хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэн ээлтэй хандахыг зорьсон зохицуулалтуудыг тусгасан. Хавсралт: 1 файл		төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1 7	Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтан мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам боловсруулна.	Журмын төсөл, баталсан шийдвэр	-	Журмыг батлуулан хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн байна.	Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/95 дугаар тушаалаар батлуулж, ХЗДХЯ-нд албан бичгээр хүргүүлснээр эрх зүйн баримт бичгийн улсын нэгдсэн сангийн бүртгэлд 6947 дугаартай бүртгэгдэж, 2024 оны 10 дугаар сарын 04-н ий өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. "ЕБС-ийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам"-ыг аймаг, нийслэлийн боловсролын газар, Боловсролын ерөнхий газарт тус тус Төрийн нарийн бичгийн даргын албан бичгээр хүргүүлж, БЕГ-аас аймаг, нийслэлийн боловсролын газруудад 7 хоног тутам зохион байгуулдаг мэдээлэл хуваалцах онлайн хуралд журмын талаар товч мэдээлэл өгч, Журмыг хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулан аймаг, нийслэлийн боловсролын газруудад Төрийн захиргааны удирдлагын	5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 12/1982 дугаар албан бичгээр хүргүүлэх зэргээр хэргжилтэд дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Хавсралт: 3 файл		
1 8	ЕБС төгсөгчдөд боловсролын баримт бичиг олгох, хөтлөх журмын төсөл боловсруулна.	Журмын төсөл, батлагдсан шийдвэр	2019 оны "Журам батлах тухай" А/156 дугаар тушаал	Журмын төсөлд санал авч, тусгасан байна.	ЕБС төгсөгчдөд олгох боловсролын баримт бичгийг загвар, түүнийг хөтлөх, олгох журмын төслийг боловсруулсан. Гадаад улсад, эсхүл олон улсын болон гадаад улсын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалтын байгууллагад суралцаж суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэнд тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичгийг олгосон боловсролын баримт бичгийг Монгол улсын ижил түвшний боловсролын баримт бичигтэй дүйцүүлэх талаарх зохицуулалтыг энэхүү журамд хамтатган оруулсан. Боловсролын ерөнхий хуулийн 9.2-т заасны дагуу Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчид ГЭРЧИЛГЭЭ олгох тул бүрэн дунд боловсролын ҮНЭМЛЭХ-гэснийг бүрэн дунд боловсролын ГЭРЧИЛГЭЭ гэж өөрчилсөн ба суурь, бүрэн дунд боловсролын баримт бичигт судалсан хичээл болон үнэлгээг бичихээс гадна тухайн хичээлийг судалсан агуулгын багтаамжийг илэрхийлсэн цагийг бичих зэрэг өөрчлөлтүүдийг тусгасан. Учир нь гадаад улсын дараагийн шатны боловсролын сургалтын байгууллагад элсэх иргэний судалсан хичээлийн агуулгын багтаамжийг тодорхойлох нэмэлт тайлбар, тодорхойлолтыг шаардах тохиолдол гардаг тул зарим улс орны боловсролын баримт бичигт болон манай улсын дээд боловсролын баримт бичигт хичээлийг судалсан агуулгын багтаамжийг академик цаг болон багц цагаар илэрхийлэн бичдэг. Мөн ерөнхий боловсролын сургуулийн	5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан болон төрөлжүүлэн, сонгон судалсан зарим хичээлийн багц цагийг цагийг их дээд сургуулийн багц цагт шилжүүлэн тооцох хэрэгцээ гарах талтайг харгалзсан болно. Хавсралт: 1 файл		
1 9	Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээний журмын төслийг шинэчлэн боловсруулна.	Журмын төсөл	-	Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх, үнэлгээний журмын төслийг шинэчлэн боловсруулсан байна.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/280 дугаар тушаалаар батлагдсан "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Тус журмын дагуу ЕБС-ийн нэгдүгээр ангийн суралцагчдын Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг зохион байгуулах тухай Боловсролын сайдын 2024 оны 08 сарын 27-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар шийдвэрийг албажуулан батлуулсан. Тус тушаалаар Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн суралцагчдын "Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ"-г 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 25-ны өдрүүдэд зохион байгуулахаар шийдвэрлэж, төсөв зардлыг баталсан бөгөөд үнэлгээг Боловсролын үнэлгээний төв нэгдсэн удирдлагаар ханган Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, аймаг, нийслэлийн боловсролын газруудтай хамтран заасан хугацаанд зохион байгуулж, тайланг боловсруулсан нь одоогоор хяналтын уншилт хийгдэж байна. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний тайлан, мэдээлэлд үндэслэн Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн сургуулийн өмнөх болон бага боловсролын багш нарт зориулсан зөвлөмж боловсруулна. Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх, үнэлгээний журмын төслийг шинэчлэн	10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					боловсруулахаар холбогдох баримт, мэдээллийг цуглуулж байна.		
3.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан ерөнхий боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах							
20	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, тайлагнах	Төлөвлөгөө, Тайлан	2023 оны төлөвлөгөө, тайлан, ЗГХХГ, ХШҮДАГ-ын зөвлөмж	Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн үр дүнгээр гарсан зөвлөмжийн биелэлтийг ханган нэгжийн гүйцэтгэлийгн тайланг болвсруулж, үнэлүүлсэн байна.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг холбогдох хууль, журам, дүрэмд нийцүүлэн МУ-ын болон боловсролын салбарын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг, яамны стратегийн хөтөлбөр, нэгжийн чиг үүрэг зэрэгт нийцүүлэн албан хаагчдын саналыг тусган, тухай бүрд боловсруулан батлуулж, тайлагнаж, дүгнүүлсэн. Ерөнхий боловсролын газар нь 2024 оны эхний хагсас жилд 8 зорилтын хүрээнд 52 ажил төлөвлөн, хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 87% биелэлттэй дүгнэгдсэн байна. Яамны бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчилж, 7 зорилтын хүрээнд 47 ажил төлөвлөсөн бөгөөд тайланг боловсруулан үнэлүүлэх ажлыг зохион байгуулж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
21	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон Монгол Улсын урт, дунд боино хугацааны бодлогын баримт бичгийн хнэрэгжилтийг нэгжийн чиг үүргийн	Тайлагналтын чанар, хугацаа	2023 оны тхйлан, ЗГХХГ, ХШҮДАГ-ын зөвлөмж	Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг тайлагнасан байна.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон Монгол Улсын урт, дунд боино хугацааны бодлогын баримт бичгийн хнэрэгжилтийг нэгжийн чиг үүргийн хүрээнд сар тутам болон хагас жил, жилээр тайлагнаж, үнэлүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн

	хүрээнд тухай бүрд тайлагнах						хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
2 2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах	ЗГҮАХ-ийн тайлангийн ЕБ-ын салбарт хамаарах үйл ажиллагааны хэрэгжилт, тайлан	2023 оны тайлан, зөвлөмж	ЗГАХ-ийн ерөнхий боловсролын салбарт хэрэгжүүлэх үйл ажиллагааг хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилт хангагдсан байна.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг сар, хагас, бүтэн жилээр Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбоотойгоор Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөний биелэлтийг сар тутам тус тус тайлагнасан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
2 3	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	Тайлагналтын чанар, хугацаа	-	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тухай бүрд хугацаанд нь тайлагнасан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн

						сар	хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
2 4	Салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Нэгж, байгууллага, иргэд, албан байгууллагаас хүссэн мэдээлэлд хариу өгсөн байдал	-	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг яамны цахим хуудасд байршуулсан байна. Иргэд, албан байгууллагаас хүссэн мэдээллийг хууль, журмын хүрээнд өгсөн байна	1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу дараах мэдээллийг яамны цахим хуудасд байршуулж, иргэд олон нийтийг мэдээллээр хангаж, санал авах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: 1. Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмын төсөл 2. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны журмын төсөл. 2. Иргэд олон нийтээс ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөц, сургалтын байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан хүссэн мэдээлэл, гомдол, саналд тухай бүрд хариу өгч, холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. 3. УИХ-ын болон ЗГ-ын гишүүд, яамд, ЕБС, БЕГ, аймгийн БШУГ, АТГ, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудаас ерөнхий боловсролын салбарын үйл ажиллагаа, бусад холбогдох мэдээлэл, дэмжлэг хүссэн албан бичиг, хүсэлтүүдийг тухай бүрд шийдвэрлэн хариу өгч ажиллалаа.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
2 5	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр	Тайлагналтын хугацаа, чанар	2023 оны тайлан, зөвлөмж	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг улирал тутам тайлагнасан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ:

	тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах.					9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	--	--	--	--	---------------------------------------	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Сургалт, семинарт хамрагдах, албан тушаалын чиг үүргийн хүрээнд ном, гарын авлага, судалгааны материал уншиж, судлах	Сургалт, семинарын ирц	-	Сургалт семинарт хамрагдсан байна.	Боловсролын яамны дотоодын болон Төрийн болон ТББ-аас зохион байгуулсан сургалт, семинарт хамрагдаж, албан тушаалын чиг үүргийн хүрээнд холбогдох хууль, журам, эрх зүйн баримт бичгүүдийг судалснаас	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					гадна Монгол бичгийг хэрэглээний чадвараа нэмэгдүүлэхэд анхаарч, үндэсний бичгийг бие даан сурч байна.		
2	БШУЯ, мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах сургалтуудад хамрагдана.	Хууль, эрх зүй, бодлогын баримт бичиг, ном товхимол, судалгаа шинжилгээний материалуудыг судлана.	-	Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ур чадвар, гүйцэтгэлийн үнэлгээний хувь ахисан байна.	Хууль, эрх зүй, бодлогын баримт бичиг, ном товхимол, судалгаа шинжилгээний материалуудыг судлана.. БЯ, мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад тухай бүрд хамрагдсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Сургалтын хөтөлбөр, үнэлгээний бодлогын удирдлага, зохицуулалт, тайлагналт хариуцсан ахлах шинжээч, Даваадорж Даваасүрэн
/...../ Огноо: